



32

**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 06 сарын 05 өдөр

Дугаар 1/15

Модот

**Эд хөрөнгийн тооллогын
комисс томилох тухай**

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1 дэх заалт, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2, 10.4 дэх заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ерөнхий боловсролын сургуулийн төрийн өмчийн эд хөрөнгө тооллого явуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: М.Өсөхцэнгэл	Бага ангийн багш
Нарийн бичгийн дарга: Б.Адъяахүү	Нийгмийн ажилтан
Гишүүд: Т.Тунгалагнаран	Бага ангийн багш
Б.Отгончимэг	Бага ангийн багш
Д.Мөнхгэрэл	Бага ангийн багш
Д.Золбоосүрэн	Бага ангийн багш
З.Гантуяа	Дотуур байрны багш

2. Төрийн өмчийн данс бүртгэлээр тулган тоолж, данс бүртгэлд тусгагдаагүй эд хөрөнгийг бүртгэх, элэгдэл дууссан хөрөнгийг ашиглах бол дахин үнэлгээ тогтоох, актлах хөрөнгийн жагсаалтыг үйлдэх ажлыг чанартай зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч (М.Өсөхцэнгэл)-д даалгасугай.

3. Эд хөрөнгийн тооллогыг 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрөөс 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн дотор чанартай зохион байгуулж, тайланг нэгтгэхийг ажлын хэсгийн ахлагч (М.Өсөхцэнгэл), нийт томилогдсон гишүүдэд үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



Д.ОТГОНДУЛАМ